



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум,
7-р баг, Жинст 0, Утас/Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.03.15 № 213

танай _____ -ны № _____ -т

**НИСЭХ БУУДЛЫН ДАРГА
Д.БАТБАЯР ТАНАА**

Төрийн Аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд танай байгууллагын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, шийдвэрийг хүргүүллээ.

Аудитын шийдвэрийг тогтоосон хугацаанд хэрэгжүүлж, хариу ирүүлнэ үү.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



07030501



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймаг дахь “Алтай” нисэх буудлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/01/-НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2022 он</p>	<p>Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас:70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Цэцэгмаа Утас: 99488754 Цахим хаяг: tsetsegmaab@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
Байгууллагын үйл ажиллагаа.....	10
Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	10
3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4. Аудитын илрүүлэлт	14
4.2.1 Залруулсан алдаа	14
4.2 .2 Төлбөрийн акт	14
4.2.3 Албан шаардлага	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
“АЛТАЙ” НИСЭХ БУУДЛЫН
ДАРГА Д.БАТБАЯР ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.03.15 № 161

танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймаг дахь “Алтай” нисэх буудлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Иргэний нисэхийн үндэсний төв төрийн өмчит ААТҮГ Говь-Алтай нисэх буудлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

07020435

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	89,000,355.56	4,188,056.63
1.1.2	Дансны авлага	14,105,262.19	12,176,448.21
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	116,676.91	168,676.91
1.1.4	Бусад авлага	1,051,818.18	20,552,526.36
1.1.6	Бараа материал	215,439,680.07	238,815,126.54
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	319,713,792.91	275,900,834.65
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	13,238,881,678.89	12,907,661,851.94
1.2.2	Биет бус хөрөнгө	2,903,402,059.06	2,902,995,000.71
1.2.7	Хойшлогдсон татварын хөрөнгө	7,518,872.64	7,928,822.15
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	16,149,802,610.59	15,818,585,674.80
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	16,469,516,403.50	16,094,486,509.45
2.1.1.2	Цалингийн өглөг		52,000.00
2.1.1.3	Татварын өр	9,743,733.49	
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	5,041,761.79	1,489,000.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	14,785,495.28	1,541,000.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	14,785,495.28	1,541,000.00
2.3.1	Өмч: - төрийн	2,899,940,000.00	2,899,940,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,549,947,057.92	1,536,222,808.62
2.3.8	Хойшлогдсон орлого	50,396,665.48	42,596,665.48
2.3.9	Хуримтлагдсан ашиг	11,954,447,184.82	11,614,186,035.34
2.3.11	Эздийн өмчийн дүн	16,454,730,908.22	16,092,945,509.44
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	16,469,516,403.50	16,094,486,509.45

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

		/төгрөгөөр/	
Мөр	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (Цэвэр)	34,938,769.64	12,481,904.93
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,648,974,270.96	1,782,400,309.60
3	Нийт ашиг (алдагдал)	(1,614,035,501.32)	(1,769,918,404.67)
4	Хүүгийн орлого	953,703.37	214,633.90
5	Бусад үйл ажиллагааны бус орлого	1,602,346,852.05	1,481,664,871.34
6	Бусад зардал	39,833,975.00	65,438,188.79
7	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(15,662,920.13)	(508,310.57)
8	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(66,231,841.64)	(353,985,398.78)
9	Татварын дараах ашиг (алдагдал)	(66,231,841.64)	(353,985,398.78)
10	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(66,231,841.64)	(353,985,398.78)
11	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	(66,231,841.64)	(353,985,398.78)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/						
Код	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,899,940,000.00	1,536,222,808.62	50,396,665.48	11,968,171,434.12	16,454,730,908.22
2	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,899,940,000.00	1,536,222,808.62	50,396,665.48	11,968,171,434.12	16,454,730,908.22
3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө залруулга					0.00
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,899,940,000.00	1,536,222,808.62	50,396,665.48	11,968,171,434.12	16,454,730,908.22
5	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал					0.00
6	Өмчид гарсан өөрчлөлт			-7,800,000.00		-7,800,000.00
7	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
8	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
9	Тайлант үеийн үр дүн				-353,985,398.78	-353,985,398.78
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,899,940,000.00	1,536,222,808.62	42,596,665.48	11,614,186,035.340	16,092,945,509.44

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөрөөр/			
Д/д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,246,544,990.51	1,059,369,606.10
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	30,053,851.14	4,664,492.20
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0	0
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	4,447,329.00	18,715,338.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	0	0
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	1,202,771,496.00	1,033,588,000.00
1.1.6	ҮҮА-ны бусад мөнгөн орлого	9,272,314.37	2,401,775.90
	Банк хоорондын гүйлгээ	6,763,329.00	
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,160,623,253.49	1,144,181,905.03
1.2.1	Ажиллагчдад төлсөн	535,122,281.64	535,071,415.79
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	156,239,332.98	145,892,688.31
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	320,496,432.00	280,867,848.95
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	40,990,921.61	49,981,078.35
1.2.5	Хүүний төлбөрт төлсөн	-	-
1.2.6	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	78,944,051.76	71,660,884.57
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	26,129,311.00	30,263,426.00
1.2.9	ҮҮА-ны бусад мөнгөн зарлага	2,700,922.50	30,444,563.06
	Банк хоорондын гүйлгээ	7,138,245.00	
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	85,921,737.02	(84,812,298.93)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	85,921,737.02	(84,812,298.93)
4	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	85,921,737.02	(84,812,298.93)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,078,618.54	89,000,355.56
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	89,000,355.56	4,188,056.63

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/				
№	ҮЗҮҮЛЭЛТ	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Хэтрэлт хэмнэлт
НИИТ ЗАРЛАГА		1,365,221,300.00	1,140,629,587.03	224,591,712.97
УРСГАЛ ЗАРДАЛ		1,365,221,300.00	1,140,629,587.03	224,591,712.97
1	БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,330,451,200.00	1,117,773,601.21	212,677,598.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	816,903,000.00	619,133,751.73	197,769,248.27
1	Үндсэн ба нэмэгдэл цалин	715,551,000.00	619,133,751.73	96,417,248.27
2	Хоолны үнийн хөнгөлөлт	101,352,000.00	-	101,352,000.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		114,366,500.00	78,887,232.12	35,479,267.88
1	Тэтгэврийн даатгал	73,521,300.00	78,887,232.12	- 5,365,932.12
2	Тэтгэмжийн даатгал	8,169,000.00		8,169,000.00
3	ҮОМШ-ний даатгал	14,704,300.00		14,704,300.00
4	Ажилгүйдлийн даатгал	1,633,800.00		1,633,800.00
5	Эрүүл мэндийн даатгал	16,338,100.00	-	16,338,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88,944,000.00	77,382,094.53	11,561,905.47
1	Гэрэл, цахилгаан	30,923,000.00	19,404,274.53	11,518,725.47
2	Дулаан, халаалт	55,511,000.00	55,487,000.00	24,000.00
3	Цэвэр, бохир ус	2,510,000.00	2,490,820.00	19,180.00
2104	Хангамж, бараа материалын зардал	65,842,700.00	62,101,827.77	3,740,872.23
1	Бичиг хэрэг	2,828,500.00	2,620,442.00	208,058.00
2	Шатахуун /тээвэр/	49,337,000.00	50,013,058.00	- 676,058.00
3	Шуудан, холбоо	5,645,000.00	3,553,763.77	2,091,236.23
5	Хог, хаягдал устгах зардал	5,838,000.00	4,094,780.00	1,743,220.00
6	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	2,194,200.00	1,819,784.00	374,416.00
2105	Нормативт зардал	9,300,000.00	9,240,000.00	60,000.00
2	Нормын болон дүрэмт хувцас	9,300,000.00	9,240,000.00	60,000.00
2106	Эд, хогшил урсгал засварын зардал	154,036,000.00	168,447,813.00	- 14,411,813.00
1	Багаж, техник хэрэгсэл	145,736,000.00	160,795,813.00	- 15,059,813.00
1.1	Барилга	22,955,000.00	36,302,708.00	- 13,347,708.00
1.2	Тоног төхөөрөмж	25,410,000.00	25,387,310.00	22,690.00
1.3	Автомашин	30,172,000.00	32,548,500.00	- 2,376,500.00
1.4	Аэродром	58,615,000.00	57,939,295.00	675,705.00
1.5	Гал унтраах зардал	8,584,000.00	8,618,000.00	- 34,000.00
2	Хөдөлмөр хамгааллын зардал	8,300,000.00	7,652,000.00	648,000.00
2107	Томиллолт, зочны зардал	23,365,000.00	21,483,021.00	1,881,979.00
2	Дотоод томиллолт	23,365,000.00	21,483,021.00	1,881,979.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,534,000.00	39,929,621.39	6,604,378.61
2	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,436,000.00	1,008,192.00	1,427,808.00
3	Даатгалын үйлчилгээ	30,318,000.00	30,263,426.00	54,574.00
4	Тээврийн хэрэгслийн татвар	632,000.00	374,100.00	257,900.00
6	Газрын татвар	12,998,000.00	8,154,080.00	4,843,920.00
7	Банкны үйлчилгээний хураамж	150,000.00	129,823.39	20,176.61
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,160,000.00	41,168,239.67	- 30,008,239.67
1	Бараа үйлчилгээний бусад зардал	11,160,000.00	11,280,500.00	- 120,500.00
2	Хичээл үйлдвэрлэлийн дадлага жийх		29,887,739.67	- 29,887,739.67
Харуул хамгаалалтын зардал		1,550,000.00	1,440,000.00	110,000.00
Үл хөдлөх хөрөнгийн татвар		26,066,000.00	16,123,285.82	9,942,714.18
Сургалт семинар		900,000.00	750,000.00	150,000.00
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг		4,600,000.00	2,899,700.00	1,700,300.00
Нэг удаагийн буцалтгүй тэтгэмж		4,600,000.00	2,200,000.00	2,400,000.00
Шагнал, урамшуулал, баяр ёслол			699,700.00	- 699,700.00
Эмнэлэгийн төлбөр		1,654,100.00	1,643,000.00	11,100.00
НИИТ ОРЛОГЫН ДҮН		18,000,000.00	22,229,288.10	- 4,229,288.10
Буулт хөөрөлтийн орлого		4,000,000.00	4,664,492.20	- 664,492.20
Зорчигч үйлчилгээний орлого		4,000,000.00	100,000.00	3,900,000.00
Бусад орлого		10,000,000.00	17,464,795.90	- 7,464,795.90

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймаг дахь “Алтай” нисэх буудлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Цэцэгмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймаг дахь “Алтай” нисэх буудал нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 178 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говь-Алтай аймаг дахь “Алтай” нисэх буудал нь Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Говь-Алтай аймгийн нутаг дэвсгэрт болон агаарын зайд нислэгийн аюулгүй байдлыг хангасан эдийн засгийн үр ашигтай агаарын навигаци нисэх буудлын үйлчилгээ үзүүлдэг байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй харин Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

ИНЕГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн баталсан 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн удирдамжийн дагуу тус байгууллагын үйл ажиллагаанд зайнаас дотоод аудит хяналт шалгалт хийсэн байна. Тус шалгалтад Говь-Алтай аймаг дахь “Алтай” нисэх буудлын 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал хугацааны үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа дүрэм журам болон дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, нягтлан бодох бүртгэл, цалин хөлсний бодолт, олголт төсөв гүйцэтгэл, дотоод хяналт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус багийн үйл ажиллагаа, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгах зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар тодруулга авч ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймаг дахь “Алтай” нисэх буудал нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардал болох 1,648.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 32.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 26.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Байгууллагын үйл ажиллагаа

Говь-Алтай аймаг дахь “Алтай” нисэх буудлын эрхэм зорилго нь “Иргэний нисэхийн салбарт аюулгүй, үр ашигтай, тогтвортой үйлчилгээ үзүүлэх”-д оршино. Байгууллагын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг “Монгол Улсын нутаг дэвсгэрт болон агаарын зайд нислэгийн аюулгүй байдлыг хангасан дэлхийн тэргүүлэх жишигт нийцсэн, эдийн засгийн үр ашигтай агаарын навигаци нисэх буудлын үйлчилгээний үзүүлэх” гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд тус байгууллага нь салбар, төлөөлөгчийн газрын статустай байна.

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Монголын агаарын тээврийг байгуулах, бэхжүүлэх асуудлаар БНМАУ ба ЗСБНХУ-ын Засгийн газар хооронд хэлэлцээр хийж, ЗХУ-ын Аэрофлот, Монголын агаарын харилцааны газрын хооронд олон улсын агаарын тээврийн шугамаар зорчигчид, ачаа тээш, шуудан тээвэрлэх журам, нөхцөлүүд, харилцан хүлээх үүрэг, хариуцлага, үзүүлэх тусламж, хамтын ажиллагааны болон үйлчилгээний үнэ, тооцоо хийх зарчмыг тодорхойлсон байна. Мөн уг хэлэлцээрээр Улаанбаатар, Москвагийн агаарын шугам нээх, БНМАУ-ын нутагт ЗХУ-ын хүч хөрөнгөөр байгуулагдсан Буянт-Ухаа, Сайншандын 20 сая төгрөгийн өртөг бүхий нисэх онгоцны буудлыг Монголын талд үнэ төлбөргүй шилжүүлэн өгөхөөр тохиролцож хэлэлцээрт БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн орлогч дарга Сономын Лувсан, ЗСБНХУ-ын Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх иргэний агаарын тээврийн удирдах ерөнхий газрын дарга С.Ф.Жаворонков нар гарын үсэг зурснаар ИАТ-ийн талаар ЗХУ-тай 1956 онд байгуулсан Агаарын харилцааны хэлэлцээрийн дагуу Улаанбаатар-Сайншандын нисэх онгоцны буудлын тоноглол, төхөөрөмж, эд хэрэглэл, ИЛ-14 онгоц 5-ыг хүлээн авч иргэний агаарын тээвэрт ашиглаж эхэлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5 “хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг

байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Тус байгууллага нь салбар, төлөөлөгчийн газрын статустай бөгөөд Говь-Алтай аймгийн үйл ажиллагааг хариуцсан төлөөлөн удирдах зөвлөлгүй, байгууллагын дарга өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, иргэний нисэхийн дүрэм болон холбогдох бусад дүрэм журам заавраа шинэчлэх, засаж сайжруулах арга хэмжээ авсан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-т “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу Говь-Алтай аймаг дахь “Алтай” нисэх буудал нь Иргэний нисэхийн ерөнхий газраас баталсан орон тоо бүтцийг баримтлан ажилласан байна.

3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Говь-Алтай аймаг дахь “Алтай” нисэх буудлын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	89.0	4.2	84.8
БХХО	0.0	0.0	0.0
Авлага	15.3	15.3	0.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	215.4	238.8	23.4
Үндсэн хөрөнгө	13,238.8	12,907.6	-331.2
Биет бус хөрөнгө	2,903.4	2,902.9	0.5
Хойшлогдсон татварын хөрөнгө	7.5	7.9	0.4
Нийт хөрөнгийн дүн	16,149.8	15,818.6	331.2
Өр төлбөрийн дүн	14.7	1.5	13.2
Богино хугацаат өглөг	14.7	1.5	13.2
Урт хугацаат өглөг	0.0	0.0	0.0
Эздийн өмч	16,454.7	16,075.3	379.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	16,469.5	16,076.8	392.7

Банк дахь мөнгөний үлдэгдэлд хугацаагүй хадгаламжийн дансанд 4.2 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд дотоодын авиа байгууллагаас авах 12.2 сая төгрөг, бусад байгууллагаас авах 1.0 сая төгрөг, цалингийн урьдчилгааны 1.9 сая төгрөг үлдэх 0.2 сая төгрөгийг ХХОАТ, НӨАТ-ын авлага эзэлж байна.

Авлагын үлдэгдэлд нэг жилээс дээш насжилттай 9.9 сая төгрөгийн авлага байна. Үүнээс Хүннү эйр ХХК-ийн төлөх 6.8 сая төгрөгийн авлагыг барагдуулахаар ИНЕГазар харьяа хуулийн байгууллагад хандан иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр гарсан байна. Бусад 3.1 сая төгрөгийн нэг жилээс дээш насжилттай авлагын тухайд өмнөх онуудад үүссэн боловч байгууллагын зүгээс барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулаагүй байна.

Тайлант онд үүссэн Аэро монголиа ХХК-аас авах 5.4 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар албан бичиг тоот хэд хэдэн удаа хүргүүлсэн боловч цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан төлөгдөөгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 238.8 сая төгрөг болж 23.4 сая төгрөгөөр өссөн нь байгууллагын үндсэн үйл ажиллагаа ковид-19 цар тахлаас шалтгаалан тогтмол биш байснаас шалтгаалжээ.

Тайлант онд 313.8 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч 290.4 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Тус байгууллага нь онгоц сумлах зориулалттай шатахуун нөөцөлдөг ба оны эцэст 42.4 тонн 119.6 сая төгрөгийн нөөцийн шатахуун бараа материалын үлдэгдэлд байна.

Оны эцэст худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгээгүй.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Үүнд шинээр 4.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, 1,557.8 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авснаар тус тус нэмэгдсэн.

Үндсэн хөрөнгөөс ТӨБЗГ-ын 2021 оны 325 дугаар тогтоолоор нийт 33.7 сая төгрөгийн өртөгтэй, 33.2 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 31 ширхэг хөрөнгийг акталсан байна.

Биет бус хөрөнгө 0.4 сая төгрөгөөр буурсан нь тус байгууллагын ашигладаг программ хангамжийг тайлант жилд тухайн дүнгээр хорогдуулсантай холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 1.5 сая төгрөгийн өр төлбөр байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт зардлын хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээг төлсөн эсвэл хүлээгдэж байгаа мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн дүнгээр зөвшөөрч тусгахаар заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад 151.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт материалын зардал буюу үндсэн материал, хангамжийн материал, БҮТЭЗ бичиг хэргийн материал, бусад материалын зардал хөдөлмөр буюу ажиллагсдын цалин, нэмэгдэл зардал буюу НДШ, засвар үйлчилгээний зардал, сэлбэгийн зардал, ашиглалтын зардал, элэгдлийн зардал хөрөнгийн татвар даатгалын зардал, газрын төлбөр, хөдөлмөр хамгааллын зардал, үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгслийн татварын зардал тээврийн зардал, бусад зардлуудыг хамруулсан байна. Үүнээс өртөгт хуваарилагдахгүй зардал байхгүй байна.

3.6 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Говь-Алтай аймаг дахь “Алтай” нисэх буудал нь орлого зардлын төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 10-5/1580 дугаар албан бичгээр тушаалаар Говь-Алтай аймаг дахь “Алтай” нисэх буудлын 2021 оны орлого, зардлын төлөвлөгөөнд тодотгол хийн шинэчлэн ирүүлсэн байна. Тайлант оны нийт орлогыг 18.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,365.2 сая төгрөг байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 122.7 сая төгрөгийг төлөвлөсөн байна. Байгууллагын 2021 оны орлого, зардлын төлөвлөгөөг анх баталсан дүнгээс 54.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 22.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,140.6 сая төгрөгийн зардал гарган, 371.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 22.2 сая төгрөг болж төлөвлөснөөс 4.2 сая төгрөг буюу 23 хувиар давсанд тайлант онд даатгалын нөхөн төлбөр орж ирсэн нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,140.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 224.6 сая төгрөг буюу 16 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь Монгол улсын засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг баримтлан ажилласан байдал гол нөлөө үзүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 147 мэдээллээс таван сая төгрөгөөс дээш дүнтэй орлого, зарлага, худалдан авалт төрлийн 7 ширхэг 149.1 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллагад завсрын аудит хийгдээгүй болно.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар тус байгууллагын шатахууны нөөц, нягтлан бодох бүртгэлийн шууд бичилтээр хийсэн гүйлгээ, байгуулсан гэрээний хэрэгжилт, гүйцэтгэлийг үзэх нь зүйтэй байна. Байгууллагын удирдлага болон нягтлан бодогч шатахууны тооцоог бодитой үнэн зөв хийж байгаа байдалд хяналт тавьж жолоочийн тооцоог спидометрээр хөтлүүлж ажиллах шаардлагатай. Мөн тус байгууллагын тухайд НӨАТ, ААНОАТ, санхүүгийн тайлангийн тусдаа онлайн эрхгүй худалдан авалт бусад гүйлгээ дээд газрын бүртгэлээр хийгдэж гүйлгээ балансаа нэгтгүүлж байна. Аудитын явцад ИНЕГ-ын улсын бүртгэлийн гэрчилгээг татаж үзэхэд аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэсэн статустай байгаа боловч Говь-Алтай аймаг дахь "Алтай" нисэх буудлын тайлант оны төлөвлөгөө гүйцэтгэлийг мөнгөн гүйлгээний тайлангаар гаргуулж нэгтгэж байгаа нь аж ахуйн нэгжийн тайлан гаргах стандарттай нийцэхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 43.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 36.3 сая төгрөгийн алдааг залруулж, 6.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

4.2.1 Залруулсан алдаа

Байгууллагын татварын тодорхойлолтод илүү тусгагдсан 16.9 сая төгрөгийн татварын илүү төлөлтийг аудитын хугацаанд татварын байгууллагатай тооцоо нийлүүлэн хасалт хийлгэж, санхүүгийн тайланд 19.4 сая төгрөгийн урьдчилж гарсан зардлыг нэмж бүртгүүлсэн.

4.2 .2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй болно.

4.2.3 Албан шаардлага

Татварын тодорхойлолтоор 1.3 сая төгрөгийн илүү, 0.1 сая төгрөгийн дутуу төлөлттэй боловч санхүүгийн тайланд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Тайлант оны эцэст санхүүгийн тайланд тусгасан 3.1 сая төгрөгийн авлага 1.5 сая төгрөгийн өглөгийг барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Тайлант онд олгосон цалингийн санг татварын тайланд 0.7 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-т "Анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Иргэний нисэхийн үндэсний төв төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар Говь-Алтай нисэх буудал	5	43.0	2	36.3			3	6.7		
Дүн		5	43.0	2	36.3			3	6.7		
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
Дүн											
Нийт дүн		5	43.0	2	36.3			3	6.7		



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 2157

Алтай хот

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Говь-Алтай аймаг дахь "Алтай" нисэх буудлын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Татварын тодорхойлолтоор 84.5 мянган төгрөгийн дутуу, 1,296.3 мянган төгрөгийн илүү төлөлттэй боловч санхүүгийн тайланд тусгаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Татварын тодорхойлолтын зөрүүг арилган тооцоо нийлж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг "Алтай" нисэх буудлын дарга Д.Батбаяр, нягтлан бодогч В.Амгаланбаатар нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР
Д.ЭРДЭНЭЧИМЭГ
Б.ЦЭЦЭГМАА



¹ Говь-Алтай аймаг Есөнбулаг сум Баянхайрхан баг Утас 70484030

07042157



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 91157

Алтай хот

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Говь-Алтай аймаг дахь "Алтай" нисэх буудлын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Тайлант оны эцэст санхүүгийн тайланд тусгасан 3,109.1 мянган төгрөгийн авлага 1,541.0 мянган төгрөгийн өглөгийг барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.4-т "Төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Санхүүгийн тайлант тусгасан өр, авлагыг барагдуулж, биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг "Алтай" нисэх буудлын дарга Д.Батбаяр, нягтлан бодогч В.Амгаланбаатар нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР
Д.ЭРДЭНЭЧИМЭГ
Б.ЦЭЦЭГМАА

8717144139
Д.А0060 9918301

¹ Говь-Алтай аймаг Есөнбулаг сум Баянхайрхан баг Утас 70484030